



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн
2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн
тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/12/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Дорноговь аймаг 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий	
	Утас: 70522734	Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn
	Аудитын менежер:	У.Оюунтүлхүүр
	Утас: 70523020	Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn
	Ахлах аудитор:	Э.Энхцэцэг
Аудитор:		Цахим хаяг: enkhtsetsege@audit.gov.mn
		Т.Мөнхтогтох
		Цахим хаяг: munkhtogtokht@audit.gov.mn



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,

Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

Дарга. 09.05 № 1-6/939

танай _____-ны № _____-т

ХАТАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ
ДАРГА С.ЭРДЭНЭБОЛД ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хатанбулаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хатанбулаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.ГАН-ӨЛЗИЙ

010020147

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	563.7	768.4
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	5,497.6	5,776.4
	Нийт хөрөнгийн дүн	6,061.3	6,544.8
	Нийт өр төлбөрийн дүн	4.5	75.0
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,056.8	6,469.8
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,061.3	6,544.8
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	6,747.0	5,216.6
	Үйл ажиллагааны зардлын дүн	5,110.5	4,752.0
	Үйл ажиллагааны үр дүн	1,636.5	464.6
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	51.7
	Үйл ажиллагааны нийт үр дүн	1,636.5	412.9
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	4,952.6	4,246.4
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	3,730.5	2,924.1
	Үйл ажиллагааны ЦМГ	1,222.1	1,322.3
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	1,239.7	1,211.4
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-17.6	110.9
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	109.9	92.3
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	92.3	203.2
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,420.3	6,056.8
	Тайлант оны үр дүн	1,636.5	413.0
	Эцсийн үлдэгдэл	6,056.8	6,469.8
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	3,292.5	3,154.0
	Урсгал зардал	2,176.9	2,242.3
	Хөрөнгийн зардал	1,115.6	911.7
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	3,269.3	3,203.4
	Улсын төсвөөс санхүүжих	1,639.1	2,102.9
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,446.5	894.8
	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	29.5	23.1
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	154.2	182.6

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хатанбулаг сум нь сумын эдийн засгийн хөгжлийн хэтийн төлөвлөгөөнд хөгжлийн алсын харааг “Амьдрах арга, нийгэмших чанар, төрт ёс, уламжлалаа шүтсэн оюунлаг иргэн, хүнээ дээдэлсэн чадварлаг удирдлагатай, олон салбар бүхий хөгжингүй эдийн засагтай, орчин үеийн хөгжлийн түвшинд хүрсэн өлгий нутаг болно” гэж тодорхойлсон байна.

Хөгжлийн хэтийн төлөвлөгөөнд дараах зорилгыг дэвшүүлсэн байна. Үүнд;

1. Бизнесийн таатай орчинг бүрдүүлэх;
2. Хөдөө, аж ахуй, аж үйлдвэрийн цогцолборыг хөгжүүлэх;
3. Нутгийн удирдлагын чадавхыг дээшлүүлэх;
4. Бүх шатны удирдлагын түвшинд хүний хөгжлийг анхаарлын төвд байлгах;
5. Байгалийн баялаг тэнцвэртэй ашиглах, цөлжилтийн эсрэг тэмцэх.

Гурав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 153 мэдээллээс 151 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Дөрөв. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

Тав. Аудитын илрүүлэлт:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 сан, 5 ахмадын сан, 1 тусгай сангийн нийт 14 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллагад дүгнэлт гаргаж, 2 байгууллага, 2 сан түүврээр хамрагдсан байна. Байгууллагын 5 ахмадын сан болон нөхөн сэргээлтийн тусгай дансны санхүүгийн тайланг аудит хийх байгууллагын тоонд оруулаагүй, аудит хийх хуваарь батлуулаагүй ба ТТЗ болон холбогдох ТШЗ-ийн санхүүгийн тайлангийн хугацаанд аудитад хамруулж, шалгасан болно.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд 2 байгууллагад “зөрчилгүй” дүгнэлт, 2 байгууллагад “хязгаарлалттай” дүгнэлт өгсөн байна.

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд 1 алдаа, зөрчил илрүүлснээс зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмжийг хүргүүллээ.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 40.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 13.9 сая төгрөгийн 4 алдааг аудитын явцад залруулж, 17.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах 11 албан шаардлага хүргүүлж, 4.4 сая төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 5.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 8 зөвлөмжийг хүргүүллээ.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Ажил гүйлгээний ангитай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт

Тайлант онд тус сумын төсвийн орлого 1,446.8 сая төгрөгийн төлөвлөгөөнөөс 915.1 сая төгрөгийн гүйцэтгэлтэй буюу 63 хувьтай биелсэн байна. Орлогыг үндэслэлгүй төлөвлөснөөс нийт 531.7 сая төгрөгөөр орлого тасарсан байна.

1.2 Өгсөн зөвлөмж

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Төсвийн орлогыг бодит тоон мэдээлэлд үндэслэн төлөвлөх, батлагдсан орлогын төлөвлөгөөг биелүүлэх талаар арга хэмжээ авч ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 09 дүгээр сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

6.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТТЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			

6.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс								Дүгнэлтийн хэлбэр
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1	ИТХ	9	13.4	2	9.6	-	-	3	3.8	4	-	хязгаарлалттай
2	ЗДТГ	8	26.7	1	4.2	2	4.3	4	13.4	1	4.8	хязгаарлалттай
3	ЭМТ	2	0.3	1	0.1	-	-	-	-	1	0.2	зөрчилгүй
4	ЕБС	5	-	-	-	-	-	3	-	2	-	зөрчилгүй
5	Цэцэрлэг	2	0.1	-	-	1	0.1	1	-	-	-	түүвэр
6	Соёлын төв	-	-	-	-	-	-	-	-	-	-	түүвэр
7	ОНХС	-	-	-	-	-	-	-	-	-	-	түүвэр
8	СХС	-	-	-	-	-	-	-	-	-	-	түүвэр
9	ТТЗ	1	-	-	-	-	-	-	-	1	-	зөрчилгүй
	НИЙТ	27	40.5	4	13.9	3	4.4	11	17.2	9	5.0	-